

Швейцарь Улс дахь Сан-Папиесд зориулсан эрүүл мэндийн даатгалын тухай танилцуулга

Швейцарь Улсад албан ёсоор оршин суух зөвшөөрөлгүй хүмүүс нь (Сан-Папиес гэж нэрлэнэ) хүн болж төрсөн үндсэн эрхээ эдлэх эрхтэй. Өвдсөн эсвэл гэмтсэн хүн Швейцарь Улсын хуулийн дагуу заавал шаардлагатай эмчилгээг авах эрхтэй. Хуулийн дагуу энэхүү эмчилгээ үнэ төлбөртэй байдаг ба та эмчилгээ болон эмний үнийг өөрөө эсвэл таны даатгал төлж барагдуулна.



Эрүүл мэндийн даатгал

Сан-Папиес нь Швейцарь Улсын аль нэг эрүүл мэндийн даатгалын албатай хуулинд заасны дагуу заавал эрүүл мэндийн даатгалын гэрээ хийх **эрх** болон **үүргийг** хүлээнэ. Эрүүл мэндийн даатгалын алба нь Швейцарь Улсад амьдарч буй бүх хүмүүсийг, амьдран суух эрхийг үл харгалзан, эрүүл мэндийн үндсэн даатгалд хамруулан даатгах ёстой.

Эрүүл мэндийн даатгал доорхи үйлчилгээний үнийг дааж төлнө, үүнд:

- Эмчид үзүүлж эмчлүүлэх болон эрүүл мэндийн үзлэг
- Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх
- Эмчийн жорын дагуу уух эмний үнэ (германаар Spezialitätenliste гэж нэрлэгдэх эмийн содон жагсаалтын дагуу)
- Жирэмслэх болон төрөх (даатгал даатгуулагчаас зардал даах хувь шаардахгүй)
- Гэмтэх

Шүдний эмчилгээ даатгалд хамаарагдахгүй.

Мэдээлэлийн нууцлалыг хадгалах

Эмч, эмнэлгийн ажилтан болон даатгалын алба нь эмчлүүлж буй эрэгтэй эмэгтэй ямар ч хүний тухай мэдээ мэдээлэлийг цагаачлалын алба эсвэл цагдаад цааш нь дамжуулан өгөх эсвэл цагдаагаас мэдээ мэдээлэл авах эрхгүй. Тэд мэдээ мэдээлэлийг нууцлан хадгалах үүрэгтэй. Энэхүү мэдээ мэдээлэлийг нууцлан хадгалах үүргээ үл биелүүлсэн бол шүүхийн шийтгэл хүлээнэ.

Үндсэн даатгалаа солих болон эрүүл мэндийн даатгалаа цуцлах

Эрүүл мэндийн даатгалыг та зөвхөн өөр даатгалын албатай даатгалын гэрээ хийсэн эсвэл Швейцарь Улсаас гарч явж байгаа тохиолдолд л цуцлах боломжтой.

Та даатгалаа 12-р сарын 31-ээр тасалбар болгон цуцлах хүсэлтэй байгаа бол таны даатгалаа цуцлах хүсэлт 11-р сарын сүүлийн ажлын өдөр гэхэд танай даатгалын албанд баталгаат захиагаар очсон байх ёстой. 300 Франкений Франчазтай Стандарт-Даатгалын гэрээтэй байсан тохиолдолд л та даатгалыг 6-р сарын 30-аар тасалбар болгон цуцалж болно, ингэж даатгалын гэрээг цуцлахдаа та гэрээ цуцлагдах гурван сарын хугацааг анхаарна уу (3-р сарын сүүл).

Гэмтэлийн даатгал

Та эрүүл мэндийн үндсэн даатгалын хамт гэмтэлийн даатгал хийлгэж болно, сар болгоны үндсэн даатгалын үнэ дээр гэмтэлийн даатгалын 20 Франкен нэмэгдэнэ гэсэн үг. Гэмтэлийн даатгал гэмтсэний дараахи эмчилгээний үнийг даана.

Долоо хоногт 8 цагаас илүү хугацаагаар ямар нэгэн ажлын газар ажил хийдэг хүмүүс зарчмын хувьд ажлын газрынхаа дагуу гэмтэлийн эсрэг даатгуулсан байдаг. Ийм тохиолдолд та эрүүл мэндийн даатгалын гэрээг хийхдээ гэмтэлийн даатгалын гэрээг хасаж болно.



Даатгалын үнэ

Эрүүл мэндийн даатгал үнэгүй бус. Даатгалд хүн **сар болгон** мөнгө төлөх ёстой. Даатгалын албад адил үйлчилгээ үзүүлэх боловч ялгаатай үнэтэй. 18 наснаас доошхи насны хүүхдийн даатгалын үнэ бага. Залуу хүмүүст (19-25 насны хооронд) ихэнх даатгалын алба хямдруулсан үнэтэй даатгал санал болгодог.

Та даатгалынхаа сар болгоны үндсэн үнэнээс гадна эмчилгээ болон эмний үнийн тодорхой нэг хэсгийг (германаар: **Franchise**) өөрөө төлнө. Энэхүү өөрөө төлөх ёстой эмчилгээ болон эмний төлбөрийн хэмжээг даатгал хийлгэхдээ даатгуулагч жилдээ 300-аас 2500 Франкенийн хооронд

байна гэж өөрөө сонгон тогтооно (хүүхдүүдийн хувьд **Franchise** 0-оос 600 Франкенд багтана). Эмчилгээний үнэ энэхүү **Franchise** нэмэлт төлбөрийн хэмжээнээс давах тохиолдолд та эмчилгээ болон эмний үнийн арван хувийг өөрөө төлөх ёстой (германаар: **Selbstbehalt**). Selbstbehalt гэж нэрлэгдэх энэ нэмэлт төлбөрийн хэмжээ жилдээ 700 Франкенээс илүү гарахгүй (хүүхдийн хувьд жилдээ 350 Франкенээс илүү гарахгүй).

Гэрийн эмчийн-Загвар: НМО эсвэл Telmed нь хямд даатгалын албанд тооцогддог боловч энд даатгуулсан хүн эхлээд заавал гэрийн эмчдээ үгүй бол НМО-төвд очиж үзүүлнэ гэсэн үүрэг хүлээх ба утсаар эхлээд зөвлөгөө авах үүрэгтэй (түргэн тусламжийн үед энэ хамаарахгүй).

Даатгалын үнийг сар болгон төлөх ёстой!

Та гурван сараас илүү хугацаагаар даатгалынхаа үнийг төлөхгүй бол даатгалын алба танд төлбөрөө төлөхийг шаардсан бичиг явуулсныхаа дараа (бас төлбөрөө төлж барагдуулах 30 хоногийн хугацаа олгосныхаа дараа) таны оршин сууж буй газрын захиргаанд мэдэгдэж даатгалын үнийг шаардан төлүүлэх болно.

Даатгалын үнийг хөнгөлөх

Орлого багатай хүнд зарим даатгалын алба даатгалын үнийг хөнгөлүүлэх өргөдөл гаргах боломж олгодог (орлогын доод хэмжээ оршин суугаа газраас хамааран өөр өөр байна). Өргөдлийг та өөрийн амьдран сууж буй газрынхаа даатгал хөнгөлөх зөвшөөрөл олгох албанд гаргах ёстой (та амьдарч буй газрын даатгалын үнэ хөнгөлөх албаны хаягыг энд дарж үзнэ үү

► www.priminfo.ch ► Даатгалын үнэ хөнгөлөх алба



Эрүүл мэндийн даатгалын гэрээг ингэж байгуулна:

1. Би өөрөө Швейрацийн аль нэгэн эрүүл мэндийн даатгалын албыг сонгоно. Би өөрөө даатгалын хэлбэр болон Franchise гэгдэх нэмэлт төлбөрийн хэмжээг тогтоож сонгоно (шаардлагатай бол) гэмтсэн тохиолдолд хэдэн төгрөгний тусламж авахаа тогтооно. Даатгалын үнийг ► www.priminfo.ch эсвэл www.comparis.ch гэсэн интернет хуудсан дээр харьцуулж үзэж болно.
2. Би өөрийн сонгосон эрүүл мэндийн даатгалын албанд даатгуулах хүсэлт гаргана. Үүний тулд би даатгалын албанд өөрийн нэр, өөрийн төрсөн он сар өдрөө түүнчлэн өөртэйгээ холбоо барих хаяг бас өөрийнхөө Postcheck- эсвэл банкны дансныхаа дугаарыг (таньдаг хүний дансны дугаар ч болно) өгнө.
3. Би сар болгон даатгалын албанаас ирсэн даатгалын төлбөрийн бичгийн дагуу даатгалынхаа сар бүрийн төлбөрийг төлнө (2014 байдлаар эрүүл мэндийн даатгал сард ойролцоогоор 300-550 Франкений үнэтэй байсан).
4. Би эмчилгээний төлбөрийн бүх хуудаснуудынхаа нэг хувийг эрүүл мэндийн даатгал уруугаа явуулна тэгээд дараа нь эмчилгээ болон эмийн төлбөрөө өөрөө төлнө. Эрүүл мэндийн даатгал маань надад миний явуулсан төлбөрийн хуудаснуудыг үндэслэн надад эмчилгээ болон эмний үнийг буцааж олгоно (анхаар: Franchise болон Selbstbehalt хасагдсан байна). Даатгал таны дансанд (төлбөр буцааж олгох данс) мөнгийг шилжүүлнэ. Зарим тохиолдолд төлбөрийн хуудас шууд эрүүл мэндийн даатгалд очдог (жишээ нь эм).
5. Эрүүл мэндийн даатгал маань эмчилгээ болон эмний үнийг дарж барагдуулахад би өөрийн тогтоосон Franchise-ийн хэмжээндээ түүнчлэн эмчилгээ болон эмний үнийн арван хувийг өөрөө төлж эмчилгээний зардал барагдуулахад өөрийн хувь нэмрээ оруулна (нэг жилд нийтдээ 700 Франкенээс илүү гарахгүй). Эрүүл мэндийн даатгал тооцоог хийнэ.
6. Миний оршин суух хаяг өөрчлөгдөх эсвэл би Швейцарь Улсаас явах болсон тохиолдолд үүнийгээ би даатгалдаа мэдэгдэнэ.



Асуух зүйл эсвэл тусламж шаардлагатай бол та өөрийн оршин суух газрын албанд хандана уу ► www.sante-sans-papiers.ch

